



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/18/НА-СА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он</p>	<p>Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: У.Батсүрэн Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48000 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р байр
Утас: 7037-3889, Факс: (876) 7037-3889
E-mail: darhanuul@caad.gov.mn

2022.03.15 № 236

таний _____-ны № _____-т

“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БАТЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан, Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211, 2021 оны 207 дугаар тогтоолын дагуу дулааны эрчим хүч хэрэглэгчдийн хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцан төлснийг бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Компанийн жилийн төлөвлөгөөнд 20 зарилтын хүрээнд 182 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээж, Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

009020315

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

Нэг. Санхүүгийн ба зорилтот түвшний гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,219,964,579.04	2,723,677,820.58
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	25,711,237,209.09	25,691,090,764.37
	Нийт хөрөнгийн дүн	28,931,201,788.13	28,414,768,584.95
	Нийт өр төлбөрийн дүн	2,482,654,802.71	1,223,198,031.70
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	26,448,546,985.42	27,191,570,553.25
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	28,931,201,788.13	28,414,768,584.95
Орлогын дэлгэрэнгүй тайлан			
	Борлуулалтын орлого (цэвэр)	10,376,277,540.07	10,926,949,756.37
	Борлуулалтын өртөг	5,734,941,383.33	6,384,731,731.16
	Нийт ашиг (алдагдал)	4,641,336,156.74	4,542,218,025.21
	Бусад орлого, зардал	4,639,609,681.60	4,653,798,342.20
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,726,475.14	(111,580,316.99)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,465,276,897.62	27,075,841,723.76
	Тайлант оны үр дүн	(16,729,912.22)	(115,728,829.49)
	Эцсийн үлдэгдэл	26,448,546,985.40	27,191,570,553.25
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Мөнгөн орлогын дүн	9,418,877,007.09	11,651,128,548.70
	Мөнгөн зарлагын дүн	9,420,814,922.71	11,335,243,325.55
	Үндсэн үйл ажиллагааны ЦМГ	(1,937,915.62)	315,885,223.15
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	24.724652	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(49,903,978.54)	(245,000,000.00)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(51,817,169.64)	70,885,223.15
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88,075,703.12	36,258,533.58
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,258,533.58	107,143,756.73
Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл			
	Нийт орлого	10,263,507,723.95	11,338,314,743.11
	Борлуулалтын орлого	10,113,507,720.62	10,926,949,916.48
	Үйл ажиллагааны бус орлого	150,000,003.33	411,364,826.63
	Нийт зардал	10,892,997,952.98	11,449,894,900.66
	Үйл ажиллагааны зардал	7,023,959,754.33	7,028,960,002.86
	Худалдаж авсан ДЭХ-ний өртөг	3,755,499,998.65	4,122,233,184.00
	Үйл ажиллагааны бус зардал	113,538,200.00	298,701,713.80
	ҮХЭ-ийн зардал	1,602,568,116.26	1,736,055,879.72
	Татварын өмнөх ашиг (алдагдал)	(629,490,229.03)	(111,580,157.55)

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

БНМАУ-ын Хүнд үйлдвэрийн яамны сайдын 1990 оны 26 дугаар тушаалаар Дархан хотын Дулааны цахилгаан станцын Дулааны шугам сүлжээний конторт Орхон хороо, Зөвлөлтийн барилгын 1-р трест, Шарын гол жимс ногооны САА, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын мэдэлд байсан уурын болон халаалтын зуухнуудын ашиглалт, үйлчилгээг хариуцуулж, Дархан хотын Дулааны станц, шугам сүлжээний газар болгон өөрчлөн байгуулсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Компанийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж ажилласан байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 139,578.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 13,067.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 11,768.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 112,394.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар анхан шатны бүрдэл хангаагүй ажил гүйлгээг бүртгэж зарлага гаргасан 9,764.0 мянга, журам зөрчиж олгосон жилийн үр дүнгийн болон сарын үр дүнгийн шагналд олгосон 3,303.7 мянга, нийт 13,067.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д заасныг зөрчиж шинэ жилийн арга хэмжээнд нийт 11,768.2 мянган төгрөг зарцуулсан тул цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Гэрээ байгуулахтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

НӨАТ төлөгчөөр бүртгэгдээгүй хуулийн этгээдтэй бараа материал худалдан авах гэрээ байгуулахдаа гэрээний дүнд НӨАТ орсон гэж тусгаснаас худалдах, худалдан авах гэрээний 4.1-т заасан 2,348.0 мянган төгрөгийн НӨАТ тооцогдохгүйд хүрч байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- НӨАТ төлөгчөөр бүртгэгдээгүй хуулийн этгээдтэй бараа материал худалдан авах гэрээг байгуулахдаа гэрээний дүнг тодорхой зааж байх

2. Шилэн дансны тухай хуультай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 18,934,705.0 мянган төгрөгийн 626 мэдээллийг байршуулахаас 112,394.7 мянган төгрөгийн 7 мэдээллийг ил тод байршуулаагүй, хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан мэдээллийг 7 дугаар сард хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

- Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(мянган төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	7	139,578.6	-	-	4	13,067.7	1	11,768.2	2	114,742.7
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	7	139,578.6	-	-	4	13,067.7	1	11,768.2	2	114,742.7